

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

2022 оны байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөнд нийт 6 зорилго 12 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

1. Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг багасгах, харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах зорилтын хүрээнд нийт 2 ажил гүйцэтгэсэн ба дунджаар 95 хувийн хэрэгжилттэй байна. Үүний үйлчлүүлэгчдэд арьс, харшлын чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийх, гарын авлага боловсруулан түгээх болон эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт судалгааг хийх төлөвлөгөөний хэрэгжилт тус бүр 100 хувь байна. ЭМС-ын 2021 оны А/816 тоот тушаалаар батлагдсан харшлаас сэргийлэх арга хэмжээний 3 зорилтын хүрээнд нийт 7 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь байна. Суурьшлын бүсийн ногоон байгууламжид ашиглах ургамлын талаар заавар боловсруулах ажлын төслийн санхүүжилтийг Эрүүл мэндийг дэмжих сангаас дэмжигдээгүй тул бүрэн хэрэгжээгүй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь байна..
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний биелэлт дунджаар 93.7 хувьтай байна. Тус арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд төлөвлөсөн нийт 7 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь, 1 ажлын хэрэгжилт 50 хувь байна. Зориулалтын тоноглогдсон автомашинаар хангах талаар ЭМЯ-нд шийдүүлэхээр албан тоотоор хүсэлт тавьсан хэдий ч шийдэгдээгүй байна.
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж эрсдэлээс сэргийлэх зорилгын хүрээнд нийт 15 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний хэрэгжилт 95.3 хувь байна. Үүнээс эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 11 арга хэмжээ, эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс төлөвлөсөн 13 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, 1 арга хэмжээ 80 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй байна. Тухайлбал, арьсны өвчний оношилгоо, эмчилгээний нийт 10 эмнэлзүйн заавар, арга аргачлал боловсруулж батлуулахаар төлөвлөсөн ба арьсны өвчний оношилгоо, эмчилгээний нийт 8 эмнэлзүйн заавар, 2 арга аргачлал боловсруулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувь байна. Угаалгын байрны барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж барилгын зураг, төсвийг батлуулсан хэдий ч Хэмнэлтийн хуулиар

улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад барилгын ажлын засвар, шинэчлэлийг ажлыг хориглосон тул түр хугацаагаар хойшлогдоод байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувь байна.

4. Тасралтгүй суралцагч байгууллага байж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилгын хүрээнд нийт 12 арга хэмжээг төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байна. Үүнээс арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг хүний нөөцөөр хангаж, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зорилтын хүрээнд 5 арга хэмжээ, гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн байна.
5. Дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлж тоног төхөөрөмжөөр бүрэн хангах зорилгын хүрээнд 5 ажил төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байна. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээ, мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлж цахим эмнэлэгт шилжих зорилтын хүрээнд 2 арга хэмжээг тус тус төлөвлөж хэрэгжүүлсэн байна.
6. Байгууллагын удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгож, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах зорилгын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байна. Үүнээс хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 5 арга хэмжээ, хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн байна.